



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 409 дүгээр тогтоолын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 409 дүгээр тогтоолд заасан хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч,
Төрийн өмчийн төлөөлөгч:

Д.Батболд
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн мэргэжилтэн

Дуудлагын худалдааны хөтлөгч:


Б.Мөнхбаатар
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Дуудлагын худалдааны тэмдэглэл
хөтлөгч

Ц.Уранчимэг
Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн
үндсэн хөрөнгийн нягтлан

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах, үр дүнг 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдөрт багтааж танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Батболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013569

ТӨБЗГ тушаал-/2023